

## УСАН СПОРТ СУРГАЛТЫН ТӨВ

### Нэг. БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХ

Анх 1969 оноос Туул голын эрэгт усны гольдрол ашиглан 50 метрийн задгай усан бассейн байгуулан улс, хотын аваргын тэмцээнийг жил бүр зохион байгуулж ирснээс гадна хүүхэд залуучуудыг усан спортоор хичээллүүлж иргэдийг усанд сэлж сургах ажлыг зохион байгуулж ирснээр монголд анх усан спортын хөгжил суурь тавигдсан байна.

Усан спорт сургалтын төв нь анх МХЗЭ-ийн Төв хорооны 1-р нарийн бичгийн дарга Л.Түдэвт битүү усан байгуулах хүсэлтийг тавьснаар 1986 онд МХЗЭ-ийн төв хорооны харьяа хүүхэд, залуучуудын усан спорт сургалтын төв бассейн нэртэйгээр анх байгуулагдаж нийслэлийн хүн амын бие бялдарыг чийрэгжүүлэх, усан спортын төрлөөр хичээллэгчдийг сургах, Иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд тусламж үзүүлэх зорилгоор үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Тус төв нь 10x6 м харьцаатай 0.6-0.8 м гүн, 600м<sup>3</sup> эзэлхүүнтэй, нэг ээлжиндээ 12-15 хүн хичээллэх жижиг ванн, 25x16 м харьцаатай, 1.7м-5.0м гүн, 1200м<sup>3</sup> эзэлхүүнтэй нэг ээлжиндээ 40-50 хүн хичээллэх том нэг ванн, цайны газар, 240 хүний суудалтай үзэгчдийн танхим, усны шинжилгээ хийдэг лаборатори, захиргаа аж ахуйн 10 гаруй өрөө тасалгаатай, ус цэвэрлэх иж бүрэн тоног төхөөрөмж, автомат ажиллагаатай агаар үлээх, соруулах агааржуулалтын системтэй нийт 214м<sup>2</sup> тайлбайтай /үүнээс ашигтай тайлбай 1349м<sup>2</sup>/ барилгатай болно.

Усан спорт сургалтын төвийн эрхэм зорилго нь: Нийслэлийн хүн амын хүүхэд залуучуудын бие бялдарыг чийрэгжүүлэх, усан спортын усанд сэлэлтийн төрлөөр хичээллэгчдийг сургах, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Усан спорт сургалтын төвийн хэтийн зорилго нь:

- Усанд сэлэлтийн мэргэжлийн хөтөлбөр боловсруулж ерөнхий боловсролын сургуулиудын хичээлийн программд оруулах
- Усан спортын тамирчдыг олон улс, тив дэлхийн болон олимпын наадамд оролцох бэлтгэлийг сайн хангаж амжилт гаргах
- Төвийн үйл ажиллагааг усан спорт, амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх, эмчилгээ чийрэгжүүлэлтийн цогцолбор болгох
- Усан спортыг хөгжүүлэх бодлого мэргэжлийн багш-дасгалжуулагч нарыг төлөвлөгөөтэйгээр мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах гэсэн зорилго чиглэлтэйгээр үйл ажиллагаагаа явуурж байна.

Тус төвийн анхны даргаар 1986-1996 онуудад Д.Баяраа ажиллаж байсан ба ажиллах хугацаандаа монгол оронд усанд сэлэх спортыг хөгжүүлж сурталчилах, усан

бассейны үйл ажиллагаа, журам, сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлсэн байна.

Мөн 10 гаруй мэргэжлийн багшийг сургаж бэлтгэснээс гадна МУБИС-д “Усанд сэлэлтийн багш-дасгалжуулагч” мэргэжлээр анги нээлгэн багш бэлтгээд байна. 33 жил усан спортоор хичээллэхдээ 50000 гаруй хүнийг усанд сэлж сургаснаас спортын мастер 12, дэд мастер 28, зэрэгтэй тамирчин 800 гаруй төрөн гарсан ба Сиднейн олимп, Японд болсон ДАШТ-д тамирчидаа бэлтгэн оруулсан байна.

Гэнэтийн осол, байгалийн гамшигаас ард иргэдийг аврах мэргэжлийн ангитай болох санаачлага гарган 1991-2000 онд УЦСЕГ, УИХГ-ын 122-р ангийн дэргэд “Аврагч” салаа байгуулан 280 гаруй хүн “Усчин-аврагч” болсон байна.

Түүний амжилтаас товч дурдвал:

- 1971-1975 онд ЗХУ-ын биеийн тамир спорт хорооны Усан сэлэлтийн багш-дасгалжуулагчийн ангийг төгссөн.
- 1980 онд спортын тэргүүний ажилтан
- 1991 оны 2 сард өвлийн марофон сэлэлтийн олон улсын холбооноос зохиогдсон хөвсгөл далайд мөстэй усанд 25 м сэлсэн
- 1998 онд “спортын мастер” цол
- 2000 онд “Усан спортын загалмайлсан эцэг” хэмээх цол өргөмжлөл
- 2003 онд хөдөлмөрийн хүндэт медаль гэх мэт олон шагнал урамшуулал авч байжээ.

Тус төв нь одоогоор усан спортын сэлэлтийн үндсэн 4 төрлөөр сургалт явуулж жилд давхардсан тоогоор 80,0-120,0 мянган хүнд үйлчилгээ явуулж байна

Үүнд:

- Анхан шат усанд сэлэлтийн хичээл /12 цаг/
- Дунд шат /өврөөр араар/ усанд сэлэлтийн хичээл /12 цаг/
- Дээд шатны /дельфин/ сэлэлтийн хичээл /12 цаг/
- Усны аэробик /12 цаг/
- Фитнесс, бялдаржуулах төв /1 сар/
- Өндөөр усанд үсрэлтийн дугуйлан
- Синхрон /усны гимнастик/ сэлэлтийн дугуйлан зэрэг сургалт, үйлчилгээ явуулж байгаа болно.

Усан спорт сургалтын төвийн одоо ажиллаж байгаа боловсон хүчин нь хүний нөөцийн өнөөгийн шаардлагыг хангаж байгаа боловч цаашдын хөгжлын чиг хандлагыг дагаж ажиллах шинэ эрэлт хэрэгцээ урган гарч байна.

Тус төвийн өнөөгийн бүтэц зохион байгуулалт нь багш-16, захиргаа үйлчилгээний-18, инженер техникийн-10 нийт 44 ажилтан албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

## Хоёр. ХӨМРӨГИЙН БАРИМТЫН ТҮҮХ

Тус байгууллага нь төрийн архивт 117 дугаар хөмрөг үүсгэсэн бөгөөд 1986-2001 оны архивын баримтанд 2003 оны 12 дугаар сарын 02-оос 2004 оны 01 дугаар сарын 07-ны өдрийг хүртэл ЭШТБ-ын ажлыг хийж, хадгалах хугацаа дууссан түрийн баримтуудыг устгалд оруулж, байнга хадгалах 13 хадгаламжийн нэгжийг төрийн архивт шилжүүлж, нийслэлийн архивын газрын архивч Д.Жаргалсүрэн, Л.Баттогтох нар акт бүртгэлээр хүлээлцсэн байна.

2013 оны 10 дугаар 10 сарын 14–ны өдрийн 78 дугаар тушаалаар С.Эдэнэтөгс миний бие архив, бичиг ажилтнаар шинээр томилогдсон.

Тус байгууллага нь 2013 онд Төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх хуваарийн дагуу 2002-2012 оны байнгын баримтаар нөхөн бүрдүүлэлт хийхээр Архивын газрын ажилтан Н.Цацралтуяагаас мэргэжил арга зүйн зааварчилгаа авч байгууллагын архивт хадгалагдаж буй 2002-2012 оны нийт хадгаламжийн нэгжид 2013 оны 10 дугаар сарын 03 –ны өдрөөс эхлэн “Эрдэм шинжилгээ техник боловсруулал”-ын ажлыг 28 –ны өдөр хийж дууссан.

2002-2012 оны нийт 223 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна. Үүнээс:

- Байнга хадгалах-102 хадгаламжийн нэгж
- Түр хадгалах-208 хадгаламжийн нэгж
- 70 жил хадгалах-19 хадгаламжийн нэгж

ЭШТБ-ын ажлыг хийх явцад Төрийн архивт хөмрөг үүсгэсэн 1986-2001 оны баримтыг архивт шилжүүлэхэд орхигдсон, мөн өмнөх данс бүртгэлд бүртгэгдээгүй, ажилчид дээр хадгалагдаж байсан зэрэг баримтаас хадгаламжийн нэгжийг ангилж цэгцлэн техник боловсруулалтын ажлыг хийж данс бүртгэлийг Нийслэлийн Архивын газарт хүлээлгэн өгөхөд бэлэн болсон.

### **ЭШТБ-ын ажлаар дараах ажлуудыг хийсэн. Үүнд:**

- Баримт бичгийг зааврын дагуу байнга, түр болон 70 жил хадгалах баримтаар ангилан ялгах
- Хэрэг болгон бүрдүүлсэн баримтыг үдэж хавтаслах
- Баримтын хуудас дугаарлах, нүүр бичилт болон баталгаа хийх, нуруу цаас наах зэрэг техник ажилбарыг хийх
- Лавлагаа мэдээллийн ач холбогдолтой болон хадгалах хугацаа дууссан баримтыг ялгаж устгах хэргийн акт үйлдэх
- Хадгаламжийн нэгжид түр дугаар өгөх
- Байнга, түр, 70 жил хадгалах баримтын данс, бүртгэл үйлдсэн.

### **ЭШТБ –ын явцад:**

- 2008-2012 оны даргын тушаалыг үндсэн үйл ажиллагааны болон боловсон хүчний чиглэлээр гаргасан гэж 2 ангилан, тушаалын дараалал, дугаар болон хавсралт бүрэн эсэхийг шалгаж, байнга, 70 жилийн бүртгэлд оруулсан,
- 2005-2012 оны санхүүгийн баримтанд нягтлан шалгалт хийж, санхүүгийн тайлан тэнцэл, цалингийн тооцооны хүснэгт зэрэг нь санхүүгийн касс харилцахад хамт үдэгдсэн, хадгалах хугацаа нь дуусаагүй тул задлалгүй түрийн бүртгэлд бүртгэв.
- 2002-2004 оны касс, харилцах, бараа материалын болон санхүүгийн холбогдолтой баримт хадгалагдаагүй. Энэ тухай өмнөх боловсон бүчин болох захирал Ё.Ганбат, бичиг хэргийн ажилтан Ц.Отгонтуяа нарт хүсэлт тавьж тайлбар хүссэн боловч хариу өгөөгүй.
- Дээд газрын тогтоол, шийдвэр, ирсэн явсан бичиг, өргөдөл гомдлыг нягтлан шалгаж үндсэн үйл ажиллагаатай холбоотой, түүх эрдэм шинжилгээний ач холбогдолтой баримтуудыг байнга авсан.
- Жилийн ажлын төлөвлөгөө, тайлан, холбогдох баримтуудыг байнга салган авч, сар, улирал, хагас жилийн төлөвлөгөө, тайлан мэдээг түрд үлдээв.
- 2002-2012 оны өргөдөл, гомдол сар, улирлын мэдээ, төлөвлөгөө, тайлан, цагийн бүртгэл зэргийг нягтлан шалгаж хадгалах хугацаа дууссан, түүх, эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй гэж үзсэн хэргийн ХН-д устгах хэргийн акт үйлдэв.

#### **Баримтын бүрдэл:**

-Байнга хадгалагдах баримтууд нь бүрдлийн хувьд: Захирлын тушаал, хурлын тэмдэглэл, дээд газрын тогтоол, шийдвэр ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээ, гэрээний биелэлт, санхүүгийн тайлан болон шалгалтын материал, жилийн ажлын төлөвлөгөө, тайлан зэрэг баримтуудаас бүрдэж байна.

-70 жил хадгалагдах баримтууд нь бүрдлийн хувьд: Захирлын “Б” тушаал цалингийн хүснэгт, цалингийн карт, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооны хуудас зэрэг баримтуудаас бүрдэж байна.

-Түр хадгалагдах баримтууд нь бүрдлийн хувьд: Дээд газраас ирсэн тогтоол, шийдвэр, ирсэн, явуулсан бичиг, бүртгэлийн дэвтрүүд, санхүүгийн улирал, хагас жилийн төлөвлөгөө, тайлан, мэдээ, журнал, жижүүрийн рапортын дэвтэр, цагийн бүртгэл зэрэг баримтуудаас бүрдэж байна.

**ЭШТБ-ын ажлын үр дүнд:** Байнга хадгалах 2002-2012 оны 102 хадгаламжийн нэгжийн бүртгэл, түр хадгалах 2002-2012 оны 208 хадгаламжийн нэгжийн бүртгэл, 70 жил хадгалах 1986-1999 оны 14 хадгаламжийн нэгж ба захирлын “Б” тушаал 2008-2012 оны 5 хадгаламжийн нэгжийн бүртгэл, эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй гэж үзсэн 1998-2011 оны 12 нэр төрлийн 72 хадгаламжийн нэгжийг устгахаар устгах

хэргийн актыг 2013 оны 10 дугаар сарын 28-ны өдөр үйлдэж, Усан Спорт Сургалтыг Төвийн дэргэдэх БНШК-ийн 2013 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 02 дугаар хурлаар хэлэлцүүлэн нийслэлийн Архивын газрын дэргэдэх БНШАЗК-ийн хурлаар оруулахаар шийдвэрлэв.